



## ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ, ШУУРХАЙ УДИРДЛАГЫН АЛБА

2018 оны 10 дугаар  
сарын 02 -ны өдөр

№

Улаанбаатар  
хот

### “МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ”-Д ХИЙСЭН СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Судалгааны ажлын зорилго: - Улсын хэмжээнд Монгол Улсын Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 17 дугаар бүлэг (Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг)-ийн 17.12 дугаар зүйлд заасан “Мал хулгайлах гэмт хэрэг”-ийн 2016-2018 онд үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал, нөлөөлөх хүчин зүйл, шалтгаан нөхцлийг тогтоож, санал зөвлөмж гаргахад судалгааны ажлын зорилго оршино.

Дээрхи зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэв. Үүнд:

1. Монгол Улсын малын тоо, төрөл, малтай өрхийн мэдээлэл;
2. Махны экспорт, үйлдвэрлэл, борлуулалтыг судлах;
3. Мал хулгайлах гэмт хэргийн статистик үзүүлэлт, гэмт хэрэг гарахад нөлөөлж буй хүчин зүйлийг тооцож, цаашдын хандлагыг тодорхойлох;
4. Мал хулгайлах гэмт хэрэг үйлдэгдсэд болон хохирогчдийн шинж байдлыг судлах;
5. Судалгааны ажлын үр дүнд тулгуурлан санал, зөвлөмж хүргүүлэх;

Судалгааны арга зүй: - Мал хулгайлах гэмт хэргийн талаарх тоон болон чанарын статистик мэдээнд үндэслэн гэмт хэргийн түвшин, өөрчлөлтийг тодорхой цаг хугацаагаар нь судлан дүн шинжилгээ хийх, цаашдын хандлагыг тодорхойлох динамик шинжилгээний арга, малын хулгайн гэмт хэрэгт нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээнд хамаарлын аргыг тус тус ашигласан. Мөн хөдөө аж ахуйн чиглэлээр хийгдсэн судалгаа, энэ салбарын хууль эрх зүйн акт, баримт бичгүүд болон дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын мэдээлэл, хэвлэл мэдээллийн хэрэгсэл дээр гарсан нийтлэл зэрэгт баримт, бичгийн анализ хийж, иргэн, бизнес эрхлэгч, эрх бүхий албан тушаалтантай фокус ярилцлага хийх байдлаар судалгааг хийсэн.

Судалгааны ач холбогдол: Цаашид мал хулгайлах гэмт хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх, анхаарах асуудлыг тодорхойлох, хэрэгжүүлэх үр нөлөөтэй арга хэмжээг оновчтой тодорхойлох.

## НЭГ. МОНГОЛ УЛСЫН МАЛ, МАЛЧИН ӨРХИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

### 1.1. Малын тоо:

Улсын хэмжээнд 2018 онд хийсэн мал тооллогын дүнгээр 66.5 сая толгой мал тоологдсон нь өмнөх оноос 241.2 мянга буюу 3.6 хувиар өссөн бөгөөд адуу 3.9 сая, үхэр 4.4 сая, тэмээ 459.7 мянга, хонь 30.6 сая, ямаа 27.1 сая толгой тоологдсон байна<sup>1</sup>.

### Зураг - 1. Бүртгэгдсэн малын тоо, малын төрлөөр



2018 он

459'7

4'380'88

3'940'09

27'124'7

30'554'8


<sup>1</sup> Статистикийн мэдээллийн нэгдсэн сан [www.1212.mn](http://www.1212.mn)

**Хүснэгт -1. Малын тоо, малын төрлөөр, мянган толгой, 2016-2018 он**

	2016 он	2017 он	2018 он
<b>Бүгд</b>	<b>61549.24</b>	<b>66218.97</b>	<b>66460.17</b>
<b>Адуу</b>	<b>3635.49</b>	<b>3939.81</b>	<b>3940.09</b>
<b>Үхэр</b>	<b>4080.94</b>	<b>4388.46</b>	<b>4380.88</b>
<b>Тэмээ</b>	<b>401.35</b>	<b>434.1</b>	<b>459.7</b>
<b>Хонь</b>	<b>27856.6</b>	<b>30109.8</b>	<b>30554.8</b>
<b>Ямаа</b>	<b>25574.8</b>	<b>27346.7</b>	<b>27124.7</b>

Малын тооны өөрчлөлтийг төрлөөр нь авч үзвэл, 2017-2018 онд хонь 445 мянган толгойгоор буюу 1.5 хувиар, тэмээ 25.6 мянган толгой буюу 5.9 хувиар өссөн бол адуу өнгөрсөн оны түвшинд, харин үхэр 7.6 мянган толгой буюу 0.2 хувиар, ямаа 222 мянган толгой буюу 0.8 хувиар тус тус буурсан байна.

**Зураг- 2. Малын бүтэц, хувиар, /2018 он/**



Мал тооллогын бүртгэлд бүртгэгдсэнээр нийт малын 46 хувийг хонь, 41 хувийг ямаа, адуу, үхэр тус бүр 6 хувь, тэмээ 1 хувийг тус тус эзэлж байна.


**Хүснэгт 2. Малын тоогоор тэргүүлж байгаа аймаг, төрлөөр, мянган толгой, /2018 он/**

	АДУУ		ТЭМЭЭ		ҮХЭР		ХОНЬ		ЯМАА	
I	Архангай	378.5	Өмнөговь	152.3	Архангай	621.2	Архангай	2 981.3	Баянхонгор	2 478.9
II	Төв	341.4	Баянхонгор	57.4	Хөвсгөл	482.4	Хөвсгөл	2 766.0	Өвөрхангай	2 245.8
III	Сүхбаатар	327.3	Говь-Алтай	43.7	Хэнтий	353	Өвөрхангай	2 588.1	Говь-Алтай	2 203.2
IV	Өвөрхангай	323.6	Дорноговь	42.8	Төв	282.3	Төв	2 449.1	Хөвсгөл	2 197.3
V	Хэнтий	318.9	Дундговь	39.3	Өвөрхангай	272.3	Хэнтий	2 353.5	Дундговь	1 716.6

**1.2. Малтай болон малчин өрхийн мэдээлэл: /2016-2018 он/**

“Малчин” гэж мал аж ахуй эрхэлж үндсэн орлогоо олдог иргэнийг<sup>2</sup> хэлнэ. Үндэсний статистикийн хорооны мэдээллийн нэгдсэн сангаас авсан мэдээллээр малчдын тоо 2016 онд 311.4 мянга, 2017 онд 303.6 мянга, 2018 онд 288.7 мянга болж жилд дунджаар 3.7 хувиар буурсан байна.

**Зураг – 3. Малчдын тоо<sup>3</sup>, /2016-2018 он/**



Насны бүлгээр авч үзвэл, 2018 оны байдлаар нийт малчдын 28.5 хувь нь 35-44 насных, 24.0 хувь нь 25-34 насных, 20.3 хувь нь 45-54 насных, 11.1 хувь нь 55-64 насных, 10.6 хувь нь 15-24 насных бол 5.6 хувь нь 65 ба түүнээс дээш насныхан байна.

“Малтай өрх” гэж жилийн 4 улирлын туршид мал дагнан маллаж, малын ашиг шим нь тэдний амьжаргааны гол эх үүсвэр болж байгаа өрхийг ойлгоно.<sup>4</sup>

<sup>2</sup> Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.9 дэх заалт


<sup>3</sup> Үндэсний статистик газар [www.1212.mn](http://www.1212.mn)

<sup>4</sup> [www.1212.mn](http://www.1212.mn) ХАА-н статистик үзүүлэлт тооцох аргачлал, ҮСХ, 2015 онд батлагдсан.

Манай улсад 2017 оны эцэст 885.6 мянган өрх бүртгэгдсэний 229.0 мянга буюу 25.9 хувь нь малтай өрх байна. Нийт малтай өрхийн 169.7 мянган өрх буюу 74.1 хувь нь жилийн дөрвөн


улирлын туршид малаа малладаг, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж буй өрхүүд, харин 59.2 мянган өрх буюу 25.9 хувь нь малыг амьдрал ахуйдаа туслах чанартайгаар өсгөн үржүүлж буй мал бүхий өрх байна.

**Зураг- 4. Малчин болон малтай өрхийн тоо, 2016-2018 он**



2018 онд нийт малтай өрхийн 40.7 хувь нь Хангайн бүсэд, 25.0 хувь нь Төвийн бүсэд, 12.1 хувь нь Зүүн бүсэд, Говийн бүсэд 21 хувь нь, Улаанбаатар хотод 1.2 хувь нь тус тус нутагшиж байна. Статистик үзүүлэлтээр малтай өрхийн тоо 2016 онд 223.7 мянга, 2017 онд 228.9 мянга, 2018 онд 230.9 мянга болж жилд дундажаар 1.6 хувиар багассан байна<sup>5</sup>.

**Зураг- 5. Малтай болон малчин өрхийн тоо, 2016-2018 он**



**Хүснэгт-3. Малтай өрхийн тоо, малын тооны бүлгээр, 2016-2018 он**

Малын тооны бүлэг	Малтай өрхийн тоо, мян.өрх			Нийт дүнд эзлэх хувь, %		
	2016 он	2017 он	2018 он	2016 он	2017 он	2018 он
<b>Бүгд</b>	<b>223.7</b>	<b>229.0</b>	<b>230.8</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
50 хүртэл малтай	49.1	48.4	48.6	21.9	21.9	21.1
51-200	75	74.4	74.8	33.5	32.5	32.4
201-500	63.1	65.3	66.4	28.2	28.5	28.8
501-999	26.6	29.5	30.2	11.9	12.9	13.1
1000-2000	9.3	10.6	10.1	4.2	4.6	4.4
2001- дээш малтай	0.6	0.7	0.7	0.3	0.3	0.3

Малтай өрхийг малын тоогоор нь бүлэглэн үзвэл, 2018 онд 200-500 хүртэлх малтай өрх өмнөх оныхоос 1.71 пунктээр, 500-1000 хүртэлх малтай өрхийн тоо 7.5 пунктээр тус тус өссөн бол 1000-аас дээш малтай өрхийн тоо 0.2 пунктээр буурсан байна. 2001-ээс дээш малтай өрхийн тоо 0.1 пунктээр өссөн дүнтэй байна.<sup>6</sup>

Малтай нэг өрхөд улсын дунджаар 288 толгой мал ногдож байгаа нь өмнөх оныхоос 15 толгой малаар өссөн. Малтай нэг өрхөд адуу 17, үхэр 19, тэмээ 2, хонь 131, ямаа 119 ногдож байна.

<sup>5</sup> [www.1212.mn](http://www.1212.mn) ХАА салбар 2017 он судалгаа

<sup>6</sup> [www.1212.mn](http://www.1212.mn) Хөдөө аж ахуйн түүвэр судалгаа 2017 он

Нэг өрхөд ногдох малын 86.8 хувь нь бог мал, 13.2 хувь нь бод мал байна. Мөн 500 хүртэлх малтай өрхөд ямааны тоо хонины тооноос давж байгаа бол 500-аас дээш малтай өрхүүдийн хувьд хонины тоо ямаанаас давж байна.

## ХОЁР. МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ЭКСПОРТ

Манай улсад мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, түүний хүчин чадал сайжирч, экспортын тоо хэмжээ 5 жилийн дундажтай харьцуулахад 7 дахин, өмнөх онтой харьцуулахад 3 дахин нэмэгдсэн байна<sup>7</sup>.

### 2.1. Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, түүний экспорт:


2018 оны байдлаар Монгол Улсад мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хадгалалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй нийт 999 аж ахуйн нэгж байгаагаас 401 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна. Үүний 260 нийслэлд, 141 орон нутагт байна.<sup>8</sup>

#### Хүснэгт - 4. Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрийн тоо, 2018 он

	Үзүүлэлт	Зөвшөөрөгдсөн үйлдвэрийн тоо	Үйл ажиллагаа явуулж байгаа
1	Нийт	999	401
2	Нийслэлд	739	260
3	Орон нутагт	260	141

Үйл ажиллагаа явуулаагүй байгаа нийт 598 аж ахуйн нэгжээс үйл ажиллагаа явуулахыг түр зогсоосон 234, үйл ажиллагааг бүрэн зогсоосон 28, бусад шалтгаанаар 6 үйлдвэр байна.

#### Зураг - 6. Улсын хэмжээнд мах үйлдвэрлэлийн хэмжээ, тонноор



Эх үүсвэр: YCX, [www.1212.mn](http://www.1212.mn)

Монгол Улсаас сүүлийн 3 жилийн хугацаанд нийт 18 улсад мах экспортолсон бөгөөд махны 70 орчим хувь нь адууны, 30 орчим хувь нь үхэр, хонь, сарлагын, Япон улсад дайвар бүтээгдэхүүнийг тус тус нийлүүлжээ. Экпортонд гарч байгаа махыг хөлдүүгээр, дулааны аргаар боловсруулан, шулсан, хатаасан, амталсан, вакуумжсан давхар цаасан уутанд савласан зэрэг байдлаар экспортолсон байна.<sup>9</sup>

#### Хүснэгт -5. Махны экспортын хэмжээ, экспортолсон улс


он	Экспорт махны хэмжээ, тонноор	Улсын тоо	Экспортолсон улс
2016 он	9400	14	БНХАУ, Япон, Вьетнам, Франц, Орос, Гонконг, Казакстан, Узбекистан, Малайз, Киркизстан, БНАСАУ, Япон, Катар, Арабын Эмират, Испани
2017 он	32300	2	Латви, БНХАУ
2018 он	69400	7	Япон, Франц, Хятад, АНУ, Орос, Казакстан, Гонконг улсад

<sup>7</sup> Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны сайтад байрлуулсан мэдээлэл 2019.02.01

<sup>8</sup> [www.1212.mn](http://www.1212.mn) Бизнес регистрийн сан


<sup>9</sup> Гаалийн Ерөнхий газрын статистик мэдээлэл

2018 онд экспортод гаргасан махыг төрлөөр нь харуулбал, нийт гаргасан махны 54.2 хувь нь адууны мах, 25.8 хувь нь дулааны аргаар боловсруулсан мах, 15.7 хувь нь боловсруулсан махан бүтээгдэхүүн, 8.7 хувь нь хонь ямааны мах, 2.3 хувь нь дайвар бүтээгдэхүүн гарсан байна<sup>10</sup>.



Зураг 7 -д мах экспортын хэмжээ 2010 он хүртэл тогтвортой байсан, 2010-2014 онд үхрийн махны экспорт багассан учир буурах хандлагатай байсан бөгөөд 2015 оноос хойш сүүлийн 4 жилд дунджаар 5 хувиар өссөн байна.

**Зураг-7. Экспортод гаргасан махны хэмжээ, төрлөөр, тонноор 2018 он.**




Эх үүсвэр: ҮСХ, [www.1212.mn](http://www.1212.mn)

## 2.2 Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын статистик мэдээ:

БНХАУ-аас мах импортлох хүсэлт ирүүлсэнтэй холбоотойгоор Мэргэжлийн хяналтын газраас 2016 онд 8835.2 тн, 2017 онд 10880.1 тн, 2018 онд 1894 тн мах экспортлох зөвшөөрлийг олгожээ.

**Зураг - 8. МХЕГазраас зөвшөөрөл авсан үйлдвэрүүдийн экспортод гаргасан махны хэмжээ, тонноор**




## 2.3 “Монголын махны холбоо”- ны 2016-2018 оны тайланд:

Монголын махны холбоонд энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 40 гаруй ХХК нэгдсэн бөгөөд одоо хоногт мал төхөөрч боловсруулах 7000 гаруй бод, 25000 гаруй бог мал төхөөрөх хүчин чадалтай 50 гаруй үйлдвэр ажиллаж байгаа ажээ. Экспортод гаргах махыг дотоодын үйлдвэрт

<sup>10</sup> ХХААХҮЯ-ны статистикийн хэлтсээс ирүүлсэн мэдээ

бүрэн боловсруулж импортлогч орны хүссэн стандартад нийцэхүйц технологи, тоног төхөөрөмжөөр төрөл бүрийн боловсруулалтыг хийж байна.

**Зураг -9. Махны холбооны мэдээллээр экспортод гаргасан махны хэмжээ, тонн:**



Дээрх үзүүлэлтүүдээс харахад экспортод гаргаж байгаа махны тоо, хэмжээ харилцан адилгүй байх тул улсын хэмжээнд мэдээллийн нэгдсэн сантай болж, улсаас экспортод гаргаж байгаа маханд хяналт тавих үйл ажиллагаа шаардлагатай байна.

### ГУРАВ. МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГ


Улсын хэмжээнд 2016-2018 онд нийт 95649 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдсаны 32704 буюу 34.1 хувь нь хулгайлах гэмт хэрэг, үүнээс 2802 буюу 8.5 хувь нь мал хулгайлах гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдсан байна. Мал хулгайлах гэмт хэргийн 2495 буюу 89.1 хувь орон нутагт, 307 буюу 10.9 хувь нь нийслэлд үйлдэгджээ.

Мал хулгайлах гэмт хэрэг 2017 онд 901 бүртгэгдэн шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 96 хэрэг буюу 11.9 хувиар, 2018 онд 1096 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 195 гэмт хэрэг буюу 21.6 хувиар тус тус өссөн байна.


**Зураг - 10. Гэмт хэргийн тоо, гэмт хэргийн төрлөөр, 2016-2018 он**



**Зураг – 11. Сүүлийн 3 жилд үйлдэгдсэн мал хулгайлах гэмт хэргийн дундаж тоо**



**Зураг –12. Мал хулгайлах гэмт хэргийн тоо, байршл, 2009-2018 он**




## ДӨРӨВ. МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДСЭН НУТАГ ДЭВСГЭР


Мал хулгайлах гэмт хэргийн 89.1 хувь нь орон нутагт үйлдэгдсэн бөгөөд орон нутагт үйлдэгдсэн хулгайлах гэмт хэргийн 24.3 хувийг мал хулгайлах гэмт хэрэг эзэлж байна.

Мал хулгайлах гэмт хэргийн гаралт Баян-Өлгий, Завхан, Баянхонгор, Хөвсгөл, Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгуудад урьд онтой харьцуулахад өссөн бөгөөд орон нутагт энэ төрлийн гэмт хэргийн жилийн дундаж 78 хэрэг гэж үзвэл Архангай, Хөвсгөл, Дорнод, Хэнтий, Төв аймгуудад илүүтэй үйлдэгдсэн байна.

**Зураг - 13. Мал хулгайлах гэмт хэргийн тоо, үйлдэгдсэн нутаг дэвсгэрээр, 2016-2018 он**



**Зураг 14-15. Мал хулгайлах хэргийн тоо, илрүүлэлтийн хувь, 2018 он**



**Зураг –16. Малын хулгайн гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлсэн байдал, 2018 он**



Мал хулгайлах гэмт хэргийн улмаас 2016-2018 онд иргэн, байгуулага, аж ахуйн нэгжид 8.5 тэрбум төгрөгийн хохирол учирсаны 3.5 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж 1.8 тэрбум төгрөгийн хохирлыг битүүмжилсэн байна.

Энэ төрлийн гэмт хэргийг шалгах эрх бүхий цагдаагийн алба хаагчид хэрэг илрүүлэх, шалгах, гэмт бурууг тогтоох, нотлох, хэргийг зүйлчлэх ажиллагаанд анхаарлаа хандуулж, хохирогчийн хуульд заасан эрхийг тайлбарлах, хэрэгжүүлэх, хохирол нөхөн төлүүлэх боломжийг бүрдүүлэх ажиллагаа хангалтгүй байгаа нь 41.1 хувийн хохирол барагдуулсан тоон мэдээнээс харагдаж




байна. Нөгөө талаас мал хулгайлах гэмт хэрэг үйлдэгсэд ихэвчлэн орлогогүй, эрхэлсэн тодорхой ажилгүй, малчид голдуу байгаа нь төлбөрийн чадваргүй гэх шалтгаанаар учирсан хохирлыг барагдуулдаггүй байна.

**Хүснэгт –6. Малын хулгайн гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ, нөхөн төлүүлэлтийг хүснэгтээр /2016-2018 он/**

2016 он		2017 он		2018 он	
Хохирол	Нөхөн төлүүлэлт	Хохирол	Нөхөн төлүүлэлт	Хохирол	Нөхөн төлүүлэлт
2.423.812.6	1.300.520.0	2.385.650.6	963.475.250	3.740.693.5	1.716.706.4


Мал хулгайлах гэмт хэрэг үйлдэгчдийн 90 гаруй хувь нь ашиг олох зорилгоор хулгай хийж, малыг нядлан, махыг нь төвлөрсөн зах, худалдааны төвөөр дамжуулан зарж борлуулдаг байна

**Зураг –17. Хулгайлагдсан малын тоо, малын төрлөөр, 2016-2018 он**




**Сүүлийн 3 жилийн байдлаар 11738 мал алдагдсаныг цагдаагийн байгууллага шалгасан бөгөөд шалгагдаагүй үлдсэн хичнээн хулгайлагдсан мал байгаа нь тодорхойгүй юм.**

**Зураг –18. Нийслэл хотын зах, худалдааны төвөөр худалдаалагдсан махны дундаж үнэ, төрлөөр, төгрөгөөр**




**Зураг –19. Мал хулгайлах гэмт хэргийн тоо, улирлаар, 2016-2018 он**






**Зураг –20. Мал хулгайлах гэмт хэргийн тоо, сараар, 2016-2018 он**




Мал хулгайлагдсан гарагаар нь авч үзвэл: - даваа гарагт 433 буюу 15.4 хувь, мягмар гарагт 423 буюу 15 хувь, лхавга гарагт 379 буюу 13.5 хувь, пүрэв гарагт 392 буюу 14 хувь, баасан гарагт 420 буюу 14.9 хувь, бямба гарагт 381 буюу 13.5 хувь, ням гарагт 374 буюу 13.3 хувь байна.


**Зураг –21. Малын хулгайн гэмт хэргийн тоо, гараг, цагаар, 2016-2018**



Цаг хугацаагаар харуулбал: 60.3 хувь нь шөнө буюу 22-06 цагт, 11.8 хувь нь 19-22 цагт, 15.9 хувь нь 14-19 цагт байна.



**Зураг - 22. Малын хулгайн гэмт хэргийн тоо, газраар, 2018 он**



Малчдын байнгын хариулгатай газрыг бэлчээр гэх бөгөөд хөдөө хээр гэдэг нь малчдын сууршлын бүсээс хариулгагүй хээрээс голдуу мал алдагдсаныг ялгаж тэмдэглэсэн байна.<sup>11</sup> Зураг 21 –ээс харахад 57.2 хувь буюу 1603 мал бэлчээрээс, 24.5 хувь буюу 689 мал хөдөө хээрээс, 18.2 буюу 510 мал бусад газраас алдагдсан байна.

*Энэ төрлийн гэмт хэрэг ажлын өдрүүдэд, хөдөө хээр, малын бэлчээрт голдуу шөнийн цагаар үйлдэгдсэн нь малчдын малаа хараа хяналтгүй, хариулгаагүй олон хоногоор орхиж байгаа нь мал хулгайлагдах үндсэн шалтгаан болж байна.*

<sup>11</sup> Цагдаагийн байгууллагын гэмт хэргийн статистик мэдээнд тусгагдсан байдал


### Мал хулгайлах гэмт хэргийн хандлагын шинжилгээ:

Монгол Улсын хэмжээнд малын хулгайн гэмт хэргийн 2003-2009 онд жилд дунжаар 9.7 хувиар буурсан бол 2009-2011 онд дунджаар 7.6 хувиар өссөн, 2011-2015 онд жилд дунджаар 17.5 хувиар буурсан бол сүүлийн 3 жилд 11.9 - 21.6 хувиар өсчээ.

Нийт 15 жилийн динамикаар авч үзвэл дунджаар 4.5 хувиар буурсан бөгөөд мал хулгайлах гэмт хэргийн олон жилийн тоонд хугацаанаас хамаарсан прогноз хийж үзэхэд 2019 онд 735, 2020 онд 646 болж мал хулгайлах гэмт хэрэг буурна гэж үзэхээр байна.

/Зураг 23/.


**Зураг –23. Мал хулгайлах гэмт хэргийн тоо, өсөлтийн хувь, 2003-2018 он**



15 жилийн хугацаанаас хамаарсан прогнозын загвар  $\hat{Y}_t = 22248.4 - 89.03t$  гарсан нь хугацаа жилээр нэмэгдэхэд малын хулгайн гэмт хэрэг 89 тохиолдлоор буурахаар байна. Статистик үр дүнг  $\alpha = 0,05$  буюу 95 хувийн магадлалтайгаар загварыг фишер, параметруудийг стюдентийн шалгуураар тус тус шалгаж үзсэн бөгөөд үнэмшилтэй ( $F = 47 > \text{онол } 2,27$ ,  $t - student 17.9; 6.86 > \text{онолын утга}$ ) гарсан.


Детерминацийн коэффициент нь  $R = 0.75$  гарсан нь 75 хувь /хүчин зүйлийн нөлөөллийн хувь хэмжээг экспортод гаргасан махны үзүүлэлтүүдтэй харьцуулахад магадлал 75 хувь, үлдсэн 25 хувь нь улсын махны нөөц мах болон бусад хүчин зүйл /-тай тайлбарлаж байна.

**Зураг –24. Мал хулгайлах гэмт хэргийн тооны прогноз, 2003-2018 он**



Гэвч сүүлийн 3 жилийн дунджаар 17 хувь өссөн, тэр тусмаа махны экспортыг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор 2017-2018 онд 21.6 хувиар өссөн нь анхаарал татаж байна. Иймээс махны экспортын хэмжээнд динамик шинжилгээ хийж үзэхэд /зураг-24/ малын хулгайн гэмт хэргийн динамик өөрчлөлт нь махны экспортын динамик өөрчлөлттэй таарч байсан учир хоорондын холбоо хамаарлыг регресс, корреляцийн аргаар тооцож үр дүнг шалгав.

**Зураг –25. Махны экспортын хэмжээ, тонн, өсөлийн хувь, 2003-2018 он**



Эх үүсвэр: YCX, www.1212.mn

**Малын хуйлгайн гэмт хэрэгт нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээ:**

2003-2018 оны 15 жилийн тоо мэдээнд үндэслэн малын хулгайн гэмт хэрэгт нөлөөлөх хүчин зүйлийн эх үүсвэрээс хамааруулан малын тоо, мал аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэл, махны экспортын хэмжээ зэрэг үзүүлэлтүүдийг авч корреляцийн матрицийг тооцов.


**Хүснэгт-7. Корреляцийн матриц**

	Мал хулгайлах гэмт хэргийн тоо	Экспортын махны хэмжээ, тонн	МАА-н салбарын нийт үйлдвэрлэлт, төг	Малын тоо, мянган толгой
Мал хулгайлах гэмт хэргийн тоо	1			
Экспортын махны хэмжээ, тонн	0.999	1		
Мал аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэлт, төгрөг	-0.753	-0.750	1	
Малын тоо, мянган толгой	-0.758	-0.756	0.936	1

Хүснэгт-7-оос харахад сонгон авсан хүчин зүйл дотроос малын тоо, мал аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэл хоёр хүчин зүйл хоорондоо мультиколеняр шинжтэй буюу бие биенээ орлох шинжтэй учир малын тоог хасав.

Малын хулгайд хамгийн их нөлөөлж байгаа үзүүлэлт нь экспортын махны хэмжээ маш хүчтэй шууд хамааралтай байсан бол дотоодын мал аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэлтэй урвуу хамааралтай байна.

**Зураг –26. Махны экспортын хэжээнээс хамаарсан малын хулгайн гэмт хэргийн байдал**



Экспортын махны хэмжээнээс хамаарсан регрессийн загварыг тооцож үзэхэд дараах хэлбэртэй гарсан.

$$\widehat{Y}_{\text{МХГХ}} = 1.009 \cdot x_{\text{Экс(мах)}} - 2040.9$$

Энэ нь махны экспортын хэмжээг 1 тонноор нэмэгдэхэд мал хулгайлах гэмт хэрэг 1 тохиолдлоор нэмэгдэхээр байгааг харуулж байна. Статистик үр дүнг  $\alpha = 0,05$  буюу 95 хувийн магадлалтайгаар загварыг фишер, параметруудийг стюдентийн шалгуураар тус тус шалгаж үзсэн бөгөөд үнэмшилтэй ( $F = 616796 > \text{хүснэгт } 2,27, t - \text{student } 449,8; 785,4 >$


хүснэгтийн утга) гарсан. Дитеминацийн коэффициент 99 хувь гарсан нь малын махыг худалдан борлуулах зорилготой хулгайлдаг гэдэг нь харагдаж байна.

**2018 онд хийсэн ХААИС, ХСИС -ийн судалгааны багаас Хэнтий аймгийн гэмт явдлын төлөв байдал, иргэдийн аюулгүй байдлыг түвшинг тогтоох түүвэр судалгаа:**

Хэнтий аймгийн 20 сумын 1688 малчдаас гэмт явдлын төлөв байдал, иргэдийн аюулгүй байдлыг түвшинг тогтоох зорилгоор хийсэн түүвэр судалгаанд үйлдэгдэж болзошгүй гэмт хэргийн 16 төрлөөр асуулга явуулахад малын хулгай гэж нийт оролцогчдын 72 хувь нь хариулсан байна. Судалгаанд оролцогчдын 43.5 хувь нь малын хулгайн гэмт хэрэгт өртөж байсан бөгөөд малаа алдах маш их айдастай байдаг гэж 4.1 хувь, айдастай байдаг гэж 23.8 хувь, дунд зэргийн айдастай гэж 31.2 хувь, айдасгүй гэж 30.3 хувь, 10.6 хувь нь огт айдасгүй байдаг гэж тус тус хариулжээ.

Малаа хариулахгүй орхих үеийн айдсыг 1-5 оноогоор үнэлүүлсэн 1–рүү тэмүүлэх тусам айдастай, 5-руу ойртох тусам айдасгүй байдлыг илэрхийлэх бөгөөд аймгийн хэмжээнд 2.2-3.08 үнэлсэн, аймгийн дундаж үнэлгээ нь 2.64 буюу малаа хариулахгүй орхих үедээ айдастай байдгаа илэрхийлжээ.

**Зураг - 27. Малаа хариулахгүй орхих үеийн айдсийн үнэлгээ, дундаж утгаар: (хөдөө)**



Судалгаанд хамрагдсан малтай иргэдийн хамгийн өндөр буюу 31.9 хувь нь хонийг 1-3 цаг эзэнгүй орхидог бол адууг бүтэн өдрийн турш 16.8 хувь, 8 орчим хувь нь 7 хоногийн турш эзэнгүй орхидог, үхрээ 6-12 цаг гэж 13.5 хувь, тэмээг 7 хоног гэж 7.4 хувь нь тус тус хариулсан байна.

**Хүснэгт-8. Малаа эзэнгүй орхидог хугацаа, малын төрлөөр, хувиар**

Асуулт	Судалгаанд хариулсан иргэдийн тоо	7 хоног	Бүтэн өдөр	6-12 цаг	3-6 цаг	1-3 цаг
Хонь, ямаа	757	0.4	2.4	2.7	7.3	31.9
Адуу	729	7.9	16.8	7.5	6.4	4.6
Үхэр	802	1.4	12.3	13.5	13.2	7.1
Тэмээ	342	7.4	4.5	1.9	3.3	3.1
<b>Аймгийн дундаж</b>	<b>658</b>	<b>4.27</b>	<b>9.0</b>	<b>6.4</b>	<b>7.54</b>	<b>11.7</b>

Эх үүсвэр: Судлаачийн SPSS21-р тооцсон үр дүн

Тус аймагт сүүлийн 3 жилд мал хулгайлах гэмт хэрэг 241 бүртгэгдсэн нь бусад аймгуудаас өндөр байгаа бөгөөд “малаа хариулахгүй орхих үеийн айдсийн үнэлгээ”-ний судалгаанд оролцогчид малаа алдах аюултай гэдгийг мэддэг, түүнээс айдастай байдаг ч хариулахгүй, хяналтгүй байдлаасаа болж гэмт хэргийн хохирч болсоор байна.

**ТАВ. МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ, ХОЛБОГДОГЧИЙН ТАЛААР**

**Мал хулгайлах гэмт хэргийн хохирогч:** - Мал хулгайлах гэмт хэрэгт 2016-2018 онд 2891 хүн хохирсон байна.


Насны байдлаар нь харуулбал: - 12.6 хувь нь 60-с дээш насны, 18.6 хувь нь 50-59 насны, 30.3 хувь нь 40-49 насны, 29 хувь нь 30-39 насны, 9.2 хувь нь 19-29 насны хүн хохирсон байна. Үүнээс харахад 61.5 хувь нь 40-өөс дээш насны хүмүүс хохирчээ.

**Зураг – 28. Малаа хулгайд алдсан хохирогчдыг насных нь бүлгээр, 2016-2018 он**




**Мал хулгайлах гэмт хэргийн холбогдогч:** - Цагдаагийн байгууллагын гэмт хэргийн статистик санд бүртгэгдсэнээр 2016-2018 онд мал хулгайлах гэмт хэрэгт 1983 хүн холбогдон шалгагдсаны 39 буюу 1.9 хувь нь эмэгтэй, 47 буюу 2.3 хувь нь насанд хүрээгүй хүн байна. Нийт сэжиглэгдэн шалгагдсан 1004 буюу 50.6 хувь бүлэглэн, 109 буюу 5.4 хувь согтуугаар, 53 буюу 2.6 хувь нь цагдаагийн байгууллагад шалгагдаж байх үедээ гэмт хэрэг үйлдсэн байх бөгөөд 351 тээврийн хэрэгсэл ашигласан, 228 буюу 11.4 хувь нь урьд ял шийтгэгдсэн хүн үйлдсэн байна. Мал хулгайлах гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн 896 буюу 45.1 буюу эрхэлсэн ажилгүй хүн, 979 буюу 49.3 хувь малчин, 1004 буюу 50.6 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.

**Зураг – 29. Мал хулгайлсан сэжигтний тоо, насны бүлгээр, 2016-2018 он**



**Зураг – 30. Сэжигтний боловсролын түвшин, дүнд эзлэх хувиар, 2018 он**



Зураг-30 –аас харахад:- 92.8 хувь буюу 1842 хүн хөдөлмөрийн насны хүмүүс байх бөгөөд боловсролын хувьд 96.6 хувь нь бүрэн дундаас доош боловсролтой байна. Энэхүү тоон мэдээллээс харахад боловсролын түвшин хүний ёс суртахуун, хувь хүний төлөвшилтэй шууд холбоотой нь харагдаж байна.

**ЗУРГАА. МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР  
ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГААС ЗОХИОН БАЙГУУЛСАН, УЛАМЖЛАЛТ АЖИЛ,  
АРГА ХЭМЖЭЭ, УЧИРЧ БУЙ ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ**

Эрүүгийн цагдаагийн албанаас мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, мал махны үнэ өссөн шалтгаан нөхцлийг тогтоох зорилгоор 2019 оны 01 дүгээр сард хэсэгчилсэн арга хэмжээг нийслэл хотын хэмжээнд зохион байгуулж, мах худалдан борлуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг зах, худалдааны төв, мах боловсруулах, төхөөрөх үйлдвэрүүдийг шалгахад улсын

хэмжээнд 2018 онд мах экспортлох тусгай зөвшөөрөл авсан 34 аж ахуйн нэгж, нийт 357.3 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй 145.106 тонн махыг экспортолсон дүн мэдээ гаргасан байна<sup>12</sup>.

Нийслэл хотын хэмжээнд их хэмжээгээр мах бэлтгэн хадгалж байгаа Сонгинохайрхан, Баянгол, Баянзүрх, Налайх дүүргийн нутаг дэвсгэрт байрлах агуулах, зоорь объектуудыг шалгахад нийт 14 аж ахуйн нэгжийн агуулахад 19 компани, БНХАУ-ын 10 иргэний нийт 2.300.3 тонн мах байгаагаас адуу 819 тн, үхэр 746.1 тн, хонь 257 тн, ямаа 389.3 тн, боловсруулсан бүтээгдэхүүн 9.2 тонн, дайвар бүтээгдэхүүн 83.2 тонн байна. Хадгалсан махны 80 орчим хувь нь БНХАУ-ын иргэдийн худалдан авсан мах эзэлж байна. Дээрх шалгалтын дүнгээс харахад бэлтгэн нийлүүлэгдэж байгаа махны 60-80 орчим хувийг БНХАУ-ын иргэд бэлэн мөнгөөр худалдан авч тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн нэрээр экспортод гаргаж байгаа тогтоогдсон байна.

Мал хулгайлах гэмт хэргийн 3 жилийн статистик тоон мэдээллийг нарийвчлан гаргаж, нөхцөл байдлыг тодорхойлсны дараа аймгуудын цагдаагийн газрын удирдлага, хариуцсан алба хаагчидтай ярилцаж, гэмт хэргийн нөхцөл байдал, хүндрэл бэрхшээлийн талаар ярилцан, санал солилцлоо. Үүнд: Завхан аймгийн цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа С.Цэрэнсамбуу, ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх хэлтсийн чиглэлийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Б.Чулуунтамир, ЭЦГ-ын Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн чиглэлийн ахлах мөрдөгч Г.Бөхчулуун, Хөвсгөл аймгийн Цагдаагийн газрын дэд дарга, цагдаагийн дэд хурандаа Д.Уртбаяр, Завхан аймгийн дэд дарга, цагдаагийн хошууч Д.Батхишиг, Төв аймгийн Цагдаагийн газрын Мал хулгайлах хэсгийн дарга, цагдаагийн ахмад Ч.Баяртогтох, Цагдаагийн бэлтгэл дэд хурандаа Хан-Уул дүүргийн Цагдаагийн 2 хэлтсийн Биокомбинат дахь цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа О.Баатарцогт, Дорнод аймгийн Цагдаагийн газрын Мал хулгайлах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Я.Цолмонбаяр, Архангай аймгийн Цагдаагийн газрын урьдчилан сэргийлэх ахлах байцаагч, цагдаагийн хошууч М.Нансал, Хэнтий аймгийн Цагдаагийн газрын Мал хулгайлах хэсгийн дарга, цагдаагийн хошууч Х.Эрдэнэбаясгалан, Завхан аймгийн Цагдаагийн газрын эрүүгийн мөрдөгч, цагдаагийн ахмад Ц.Мөнхбаяр, Баянхонгор аймгийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад Г.Анхбаяр, Өмнөговь аймгийн Цагдаагийн газрын урьдчилан сэргийлэх ахлах байцаагч, цагдаагийн ахмад Н.Төгсбаяр, Сэлэнгэ аймгийн Мэдээлэл судалгааны ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Д.Отгонбаатар нартай ярилцсан.

***Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хийж буй ажил, хүндрэл бэрхшээл, анхаарах зүйл:***

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдэж байгаа малчдын уулзалт, зөвөлгөөн, нэгдсэн, хэсэгчилсэн арга хэмжээ, хяналт, шалгалт, сургалт сурталчилгаа, санамж сэрэмжлүүлэг тарааж, ухуулга яриа хийсэн зэрэг ажлыг тогтмол хийж байгаа бөгөөд онцлох ажил, хүндрэл бэрхшээл, анхаарах асуудлын талаар дурьдвал:

***Онцлох ажил:***

Завхан аймгийн Цагдаагийн газраас 2017 оноос малчдын бүлэг, нөхөрлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх чиглэлээр ажиллаж, одоо 51 малчдын бүлэг, нөхөрлөл сумдад ажиллаж байна. Тэдний үйл ажиллагааг сэргээн, идэвхижүүлж, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр аймгийн Засаг дарга, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлтэй хамтран 2018 онд “Амар амгалан Завханы төлөө” аяныг 24 сумдын дунд зохион байгуулж, аяны дарцаг, дэвтэр аялуулан шилдэгээр шалгарсан нэг сумын малчдын бүлэг, нөхөрлөлд 1 сая төгрөгөөр шагнаж урамшуулсан нь бүлэг нөхөрлөлүүдийн өрсөлдөх, үйл ажиллагаа нь идэвхжүүлсэн бөгөөд Цагаанхайрхан сум шалгарч тус сумын ГХУСАЗСЗ дарга Л.Бат-Амгаланд 1 сая төгрөгийг гардуулж, малчдыг урамшуулсан байна. Завхан аймгийн Засаг дарга аймгийн төсвөөс 105 сая төгрөгийг шийдвэрлэн “Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Мал эмнэлгийн гэрчилгээ”-ний хяналтын системийг Мал Эмнэлгийн Ерөнхий газартай хамтран аймгийн бүх сумдад энэ оны 5 сараас эхлэн хэрэгжүүлээд

<sup>12</sup> ЦБ-аас 2019 оны 01 дүгээр сард зохион байгуулсан хэсэгчилсэн арга хэмжээний тайлангаас

байна. Олон улсын стандартад нийцүүлэн боловсруулсан веб, технологид суурилсан энэхүү системийг нэвтрүүлснээр мал эмнэлгийн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хэрэгжүүлэх, анхан шатны нэгжийн ажлын үр дүнг баталгаажуулах, халдварт өвчингүй аймаг, болж, малын гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа хэрэглэгчдэд шаардлагатай мэдээлэл, баримт нотолгоог харуулах, шилжилт хөдөлгөөнийг хянах, мал, амьтны халдварт өвчнийг тандах, эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх, хулгайн мал тээвэрлэгдэн худалдаалагдахаас урьдчилан сэргийлэх зорилго бүхий хяналтын системд орсноор малын гарал үүслийн гэрчилгээг хяналтандаа авсан үр дүнтэй ажлыг идэвхитэй эхлүүдээд байна.

Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газраас Шүүхийн байгууллагатай хамтран мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг зохион байгуулж, энэ ажлын хүрээнд их хэмжээний хохиролтой болон олон холбогдогчтой мал хулгайлах гэмт хэргийн шүүх хурлыг “олон нийтэд нээлттэй”-ээр Бөмбөгөр, Бууцагаан, Баацагаан, Богд, Жаргалант, Өлзийт зэрэг сумдад зохион байгуулжээ. Уг шүүх хуралд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга нар, тухайн суманд оршин суух ажилгүй, гэмт хэрэгт холбогдож болзошгүй хүмүүс, малчдыг оролцуулан нээлттэй хийсэн байна. Нээлттэй шүүх хурлын дараа иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч, шаардлагатай мэдээ, мэдээлэл болон хууль эрх зүйн зөвлөгөө өгч, иргэдээс ирүүлсэн хүсэлтүүдийг шийдвэрлэсэн байна. Энэ арга хэмжээний гол үр дүн нь иргэд болон малчдад энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг таниулах, өсвөр насны хүүхэд, залуучуудыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөлөөллийг үзүүлсэн байна. Мөн малчидтай уулзалт хийж бод малд GPS суулгах ажлыг зохион байгуулахаар Spotter ХХК-тай хамтран судалгааны ажлыг тус аймгийн Бөмбөгөр сумаас эхлүүлээд байгаа нь орон нутагт хэрэгжүүлмээр ажил болжээ.

***Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр үр дүн үзүүлсэн “Уламжлалт ажил”:***

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг дан ганц цагдаагийн байгууллага хийхэд хүн хүч, зардлын хувьд хүндрэлтэй тул нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас орон нутгийн удирдлагаас ГХУСС салбар зөвлөлтэй хамтран малчдын бүлэг, нөхөрлөлийн үйл ажиллагааг сэргээх, идэвхжүүлэн, чиглүүлэх ажилд биечлэн оролцож, үүрэг чиглэл өгөн, санаачлагатай ажиллах шаардлагатай байна. 2000-2005 онд ХУД-ийн 12,13,14-р хороонд мал хулгайлах гэмт хэрэг ихсэж /сард 60-70 орчим/ нөхцөл байдал хүндэрсэн тул ХЗДХ сайд Ц.Нямдоржоос өгсөн үүргийн дагуу Биокомбинатад цагдаагийн хэсэг байгуулагдан, нутгийн оршин суугчдын бүрэлдэхүүнтэй малчдын бүлэг, нөхөрлөлийн үйл ажиллагааг идэвхтэй өрнүүлснээр мал хулгайлах гэмт хэргийн илрүүлэлт 98

хувьд хүрч, хэргийн гаралт 1-3 гэмт хэрэг болтлоо буурч байсан тухай тухайн үед цагдаагийн тасгийн даргаар ажиллаж байсан цагдаагийн бэлтгэл дэд хурандаа О.Баатарцогт ярьж байлаа. Тэрээр орон нутгийн цагдаагийн удирдлага малчдын бүлэг, нөхөрлөлийн үйл ажиллагааг идэвхитэй зохион байгуулж, малчидтай хамтарсан хяналтыг тогтоож чадвал энэ төрлийн гэмт хэргийг бууруулах боломжтой, урамшуулалыг дүүргийн ГХУССЗ-өөс шийдвэрлэж, хийж байгаа ажлаа иргэдэд мэдээлэн, сурталчилж чадвал мэдээлэл, харилцаа хөгжсөн энэ цагт уг гэмт хэрэг буурах бүрэн боломжтой. 2002 оны Эрүүгийн хуулинд мал хулгайлах гэмт хэргийг бие даасан бүлэг байсныг өөрчилж өмчийн хулгайн хэлбэрт оруулснаар малын хулгайч нарт оногдуулах ял хөнгөрч, энэ төрлийн гэмт хэргийн гаралт ихэссэн гэж үздэг тухай ярьж байлаа.

***Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд алба хаагчдад учирч буй хүндрэл бэрхшээл:*** Орон нутагт мал хулгайлах, түүнийг илрүүлэх чиглэлээр ажиллаж байгаа алба хаагчдад учирдаг хамгийн хүндрэлтэй зүйл нь машин техник, бензин тосны асуудал байдаг байна. Хариуцсан албан хаагч гарсан хэргийг илрүүлэн мөрдөн шалгах ажиллагаа хийгээд шилжүүлдэг ч прокурор, шүүхийн байгууллагаас хөнгөн ял оногдуулдаг, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг саатуулах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авдаггүй, хангалттай нотлох баримт, үндэслэл гаргасан ч үндэслэлгүй гэж үзэн гадуур шалгаж, улмаар хөнгөн ял оногдуулж байгаа нь малын хулгайч нарт ял завших, цаашлаад дахин гэмт хэрэг үйлдэх боломж бололцоог олгож байна. Мөн одоо ажиллаж байгаа өмгөөлөгчид урд өмнө шүүх болон прокурорын байгууллагад ажиллаж байсан хүмүүс байх бөгөөд албан тушаалтан нартайгаа үгсэн



тохиролцон хэргийг шийдвэрлэдэггүй буцаадаг, хэрэгсэхгүй болгодог, ихэвчлэн торгуулийн болон тэнсэн ял оногдуулж байгаа нь цагдаагийн алба хаагчдын ажлыг хүндрүүлж байна.

Мөрдөгч нар гэмт хэрэг үйлдсэн этгээдэд таслан сэргийлэх арга хэмжээ авах зорилгоор эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах санал гарган прокурорт хүргүүлэхэд хяналтын прокурорууд саналыг 14 хоногийн дотор хянаж шийдвэрлэнэ гэсэн байдлаар хандаж, яллагдагчаар татах нь удааширдгаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа тасралтгүй явуулах зарчим алдагдах, гэмт хэрэг үйлдсэн этгээдүүд оргон зайлах, бусад этгээдүүдтэй мэдүүлгээ нэгтгэн мөрдөн шалгах ажиллагаанд зориудаар саад учруулах зэрэг хүндрэлийг үүсгэдэг байна.

Хүн ам ихтэй, зам дагасан, зах зээлд ойрхон, отор нүүдэл ихтэй аймгуудад энэ төрлийн хулгай илүүтэй гарахын зэрэгцээ тухайн орон нутгийн удирдлагаас малын хулгайн чиглэлээр бодлого боловсруулж санаачлагатай ажилладаггүй, цагдаагийн байгууллагатай хамтрах, тэдэнд дэмжлэг туслалцаа үзүүлэх ажил хангалтгүй, нэгдсэн арга хэмжээ, аяны үеэр бага хэмжээний бензин өгсөн төдийгөөр өнгөрөөдөг, бод малын үнэлгээг тогтоох шаардлагатай үед /хурдан морьт гм/ үнэлгээ хийх эрхтэй компани аймаг бүрт байхгүй, 1 бод малын үнэлгээ гаргахад 35.000- 50.000 төгрөгийн зардал гардаг зэрэг хүндрэл бэрхшээл алба хаагчдад учирдаг байна.

Цагдаагийн нэгж дээр дагнасан мөрдөн байцаагч нар малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр үр дүнтэй ажиллаж байсан боловч шинэ бүтцээр 5 аймагт малын хулгайтай тэмцэх хэсэг бусад аймагт нэг ахлах мөрдөгч ажиллаж байгаа нь хүн хүчний хувьд маш хангалтгүй байна.

Мөн орон нутгийн цагдаагийн газрын хөдөө сумдад ажиллаж байгаа алба хаагчид унаа тээврийн хэрэгсэл хүндрэлтэй байна. Аймгийн хэмжээнд 2-3 сумын цагдаагийн хэсэгт хуучивтар авто машинтай, 4-5 сумын цагдаагийн алба хаагч авто машин байтугай мотоцикл ч байхгүй байгаа нь хурдан унаатай, зэвсэглэсэн, бүлэг зохион байгуулалттай хулгайч нарыг цаг алдалгүй илрүүлэх, баривчилхад хүндрэлтэй учруулж байна. Мал хулгайлах гэмт хэрэг үйлдэгчид 2-3 автомашинтай, жижиг тэргээр түрүүлэн явж цагдаагийн болон бусад хяналтын постын байршлыг урьдчилан тогтоож, хулгайн мал тээвэрлэн яваа авто машиныг постыг тойруулан алсуур нэвтрүүлдэг, зарим газруудад зоорь ухаж нуун далдалдаг байна.

**Мал хулгайлах гэмт хэргийн танилцуулгаас:** - Эрүүгийн цагдаагийн газрын Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн эрүүгийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч Д.Санданбалир, цагдаагийн ахмад Х.Даваадондог нарын шалгасан . . . . . тоот хэрэг.



1. Г.Хадбаатар, Э.Нямдорж нарын 6 хулгайч бүлэглэн бод мал дагнан хулгайлдаг бөгөөд 41 адуу, 10 тооны үхэр, нийт 51 тооны тооны бод малыг 15 удаагийн үйлдлээр хулгайлсан. Мал хулгайлах гэмт хэрэг үйлдэхдээ 2-3 авто машин ашигладаг, малыг эмээл, хазаартай мориор

эзэнгүй хашаа, хороо, зэлүүд газарт тууж аваачиж нядлаад, чингэлэгтэй тээврийн хэрэгсэлд тусгай төхөөрөмж ашиглан ачиж Налайх дүүргийн 1 дүгээр хороо Уурхайчдын 15-603 тоот хашаанд авч ирж тусгайлан ухаж бэлтгэсэн зооринд эвдэж янзалдаг байна. Мал хулгайлах гэмт хэрэгт шалгагдаж байх үедээ оргосон Э.Нямдорж нь Төв аймгийн Баяндэлгэр сум, Багануур, Налайх дүүргийн хооронд хулгайн мал, мах зөөж байсан нь тогтоогдсон. Тэд Төв аймгийн Баяндэлгэр сумын малын эмч Б.Пионероос адуунд гарал үүслийн бичиг хууль бусаар авсан тогтоогдсон байна.


2. Г.Хадбаатар, Г.Бямбадорж нар гэр бүлээрээ мал хулгайлах гэмт хэрэг бүлэглэн үйлддэг, хутга, сүх, олс зэргийг бэлтгэн 7 хоногт 2-3 удаа бусдын малыг хулгайлдаг, Монголын бүх мал миний л мал, баяд малын хулгайч хэзээ ч баригдахгүй, үйлдсэн хэргээ хүлээхгүй гэх зэргээр тангараг өргөх, мэдээлэл өгсөн гэрч, хохирогчийг хотыг чинь харлуулна, миний малыг хардаг гэдгээ мэд гэх мэт доромжлох, мэдээлэл өгсөн малчны малыг нь хулгайлах, зах дээрээс нядалсан малын толгой авч өөрсдийн хулгайлсан малын толгойн оронд ашиглах, бусдын хээлтэй гүү, хурдан морийг нядлан шулсан хэрэг үйлдлүүд нь нотлогдон шалгагдсан байна. Гэмт хэргийн улмаас 23 иргэдийн 316 толгой мал /бод 35/ бог 281/ алдагдан нийт 46.615.000 сая төгрөгийг хохирол учруулжээ. 2006-2018 он хүртэлх хугацаанд хуулийн байгууллагуудад яллагдагч Г.Хадбаатар нь 10-15 удаа шалгагдсан боловч гэмт хэргийн үйлдлийн арга нь далд нууц, ул мөр, эд мөрийн баримтаа ямар нэг ул мөргүйгээр устгаж хэвшсэн, хэргээ үнэн зөвөөр мэдүүлэхгүй байцаан шийтгэх ажиллагааг хүндрүүлэх, хууран мэхлэх зэргээр прокурор, шүүхийн шатанд хэргийг хэрэгсэхгүй болгуулж ял завшиж сурсан. Иймэрхүү этгээдүүд эсрэг засаг захиргаа-цагдаа-малчин нарын харилцан холбоо, технологийн дэвшил, хуулийн байгууллагын хамтын ажиллагаа зэргийг сайжруулах хэрэгцээ шаардлага байгаа нь харагдаж байна.



## ДОЛОО. МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ

**7.1. Прокурорын байгууллагын хяналт** - Прокурорын байгууллагаас 2018 онд урьд оны дугаартай 364, тухайн оны дугаартай 1050 хэрэг, нийт 786 яллагдагчтай 1414 хэрэгт прокурорын хянан шалгах ажиллагааг явуулсан байна.<sup>13</sup>

### Зураг –30. Мал хулгайлах гэмт хэрэгт тависан хяналт:



Мал хулгайлах 527 яллагдагчтай 326 хэрэгт хянан шалгах ажиллагаа явуулж, шүүхэд шилжүүлэн, 210 хэрэг бүртгэлтийн хэргийг хаан, 84 хэргийг нэгтгэж, 1 хэргийг түдгэлзүүлэн, 5 хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн байна. Одоо прокурорын хяналтанд 788 хэрэг байна.

### 7.2. Шүүхээр мал хулгайлах гэмт хэргийг шийдвэрлэгдсэн хэрэг. /2018 он/

<sup>13</sup> Улсын ерөнхий прокурорын дэргэдэх гэмт хэрэг, зөрчлийн бүртгэл, дүн шинжилгээний төвөөс ирүүлсэн статистик мэдээлэл.

Шүүхээс 2018 онд мал хулгайлах гэмт хэргийн урьд оны дугаартай 14, тухайн оны дугаартай 263, нийт 277 хэрэгт холбогдсон 467 шүүгдэгчийн гэм буруутай үйлдлийг тогтоох зорилгоор эрүүгийн хариуцлага хүлээлгэх хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж, 361 шүүгдэгчтэй 234 хэргийг шийдвэрлэсэн байна.<sup>14</sup>

**Зураг – 31. Мал хулгайлах гэмт хэргийн шийдвэрлэлт:**

<p>01) 2018 онд Шүүхээс 5 хүнд холбогдох 1 хэргийг хэрэгсэхгүй болгож, 19 хүнд холбогдох 14 хэргийг буцаан, 47 хүнд холбогдох 6 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж, 40 хүнд холбогдох 23 хэрэг шийдвэрлэсэн байна.</p>	<p>02) Хялбаршуулсан журмаар 68 хүнд холбогдох 52 хэргийг, ердийн журмаар 293 хүнд холбогдох 182 хэргийг шийдвэрлэжээ.</p>
<p>03) Шүүх 233 хэргийг дан бүрэлдэхүүнтэй, 1 хэргийг бүрэлдэхүүнтэй шийдвэрлэсэн.</p>	<p>04) 154 хэрэгт хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж, 193 хэрэгт ял шийтгэсэн.</p>
<p>05) Давхар зүйл ангиар ял шийтгүүлсэн 5, урьд ял шийтгүүлсэн 99 шүүгдэгч байна. Шүүгдэгчдийн 46 нь 2 дахь удаа, 53 нь 3 буюу түүнээс дээш удаа урьд нь ял шийтгүүлжээ.</p>	<p>06) Шүүхээс 2 шүүгдэгчид 950.0 төгрөгөөр торгох ял, 109 хүнд нийтэд тустай ажил хийлгүүлэх, 9 хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авч, 82 шүүгдэгч хорих ял шийтгүүлжээ.</p>
<p>07) Шүүхээс 6 сараас -3 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгүүлсэн 61 шүүгдэгч, 1-3 жил хорих ял шийтгүүлсэн 14 шүүгдэгч, 3-5 жил хорих ял шийтгүүлсэн 7 шүүгдэгч, торгох ял, 5-аас дээш жил ял шийтгүүлсэн шүүгдэгч байхгүй байна.</p>	<p>08) Үүрэг хүлээлгэж, эрх хязгаарласан 60, хөрөнгө орлогыг хураасан 40 хүн байна. Ял шийтгээгдсэн хүмүүсийн</p>

**7.3. ШШГЕГ-ын харьяа хорих ангид ял эдлэж буй ялтны мэдээлэл /2016-2018 он/**

Монгол улсын Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 17.12 зүйл ангиар ял шийтгэгдсэн 2016 онд 204, 2017 онд 25, 2018 онд 49 хүн ШШГЕГ-ын харьяа Хорих ангиудад ял эдлэж байна.<sup>15</sup> /2015 оны Өршөөл үзүүлэх тухай хууль болон 2017 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотой хуулийн тэгшитгэлд хамрагдаж нийт 1475 ялтан суллагдсан байна/

**НАЙМ. МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ, ТҮҮНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ТӨРӨӨС ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ОНЦЛОХ АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ**

Монгол Улсын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсгийг үндэслэн “Монгол мал” хөтөлбөр одоо 2 дугаар шатанд /2016-2021 он/ хэрэгжиж байна. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр эдийн засаг нийгмийг хөгжүүлэх төсөв болон олон улсын байгууллагын санхүүжилтээр олон талт ажлууд хийгдэж байна. Онцлон дурьдвал:

**8.1. Мал эмнэлгийн гэрчилгээ:** - Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Малын генетик нөөцийн тухай хууль 2017 оноос хэрэгжиж, малын эрүүл мэндийн асуудлыг төр мэдэлдээ авч, босоо тогтолцоотой Мал эмнэлгийн ерөнхий газар байгуулагдсан. Тус газраас Швецарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр “Ногоон алт малын эрүүл мэнд” төслөөр “Мал эмнэлгийн гэрчилгээ”-г цахимжуулж, хянах системийг энэ оны 05 дугаар сараас Завхан аймгаас хэрэгжүүлж эхлээд байна. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7.4.2-т “нийтийг хамарсан арга хэмжээнд оролцуулах, хээлтүүлэгт ашиглах, худалдах, төхөөрөх зорилгоор мал, амьтныг сум, дүүргийн нутаг дэвсгэрээс гаргахдаа мал эмнэлгийн улсын байцаагчаас мал эмнэлгийн гэрчилгээ авч бүртгүүлэх тухай”<sup>16</sup> заасан. Өмнө нь мал хулгайлах гэмт хэрэг

<sup>14</sup> Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх шүүхийн мэдээлэл, судалгааны хүрээлэнгээс ирүүлсэн статистик мэдээ.  
<sup>15</sup> ШШГЕГ-ын хорих ял эдлүүлэх албаны хоригдогсдын шилжилт, хөдөлгөөн дүн бүртгэлийн тасгийн мэдээ  
<sup>16</sup> Мал эмнэлгийн эрүүл мэндийн тухай хуулиас



үйлдэгсэд нядалсан малаа махны ченжүүдэд нийлүүлдэг бөгөөд мал, махны гарал үүслийн гэрчилгээг мал эмнэлгийн эмч нар, багийн дарга нараас ямарч хяналтгүйгээр мөнгөний баримт хэлбэрээр бичдэг байсан нь шилжилт хөдөлгөөн хийх, эрүүл хүнс бэлтгэж, түгээх, хяналт тавихад хүндрэлтэй байсныг доорх системд оруулснаар хяналт тавих ажиллагаа бүрэн шийдвэрлэсэн.<sup>17</sup>

**“Малын эрүүл мэндийн эргэн мөшгих хяналтын систем”:** Мал, амьтан тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүнд мал эмнэлгийн гэрчилгээ олгох үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилго бүхий “Малын эрүүл мэндийн эргэн мөшгих систем” энэ оны 5 сараас эхлэн таван аймагт хэрэгжүүлж эхлээд байна. Энэ системээр дамжуулж, аль аймгийн ямар сумаас, хэн гэх малчны хотноос гарсан мал болохыг харах бөгөөд технологийн дэвшлийг ашиглан гарал үүслийн бичгийг танилын шугамаар авч хулгайн мал тээвэрлэдэг үйл ажиллагааг хязгаарласан байна. Энэ систем нь мал малчны хотноос малын эмчийн зөвшөөрөлтэйгээр гараад, замын хяналтын постыг нэвтэрч улмаар үйлдвэрт, үйлдвэрээсээ боловсруулагдаад хүнсний зах, дэлгүүрт очих бөгөөд үйлчлүүлэгч худалдан авч буй махны гарал үүслийг андройд үйлдлийн системтэй утсанд тусгай апплейкшнийг суулгасан бол QR кодыг уншуулж, шаардлага хангахуйц махаар үйлчлүүлж байгаа эсэхээ харах боломжтой юм байна.

**Зураг – 32. Малын эрүүл мэндийн эргэн мөшгих хяналтын систем**



Энэ системээс харахад сумын хэсгийн төлөөлөгч, цагдаа нар /одоогоор интернетэд 249 сумын цагдаагийн хэсэг холбогдсон бөгөөд 72 суманд энэ оны эхний 6 сард багтаан бүрэн холбоно<sup>18/</sup> интернет сүлжээг ашиглан ажлын компьютер болон гар утсандаа апплейкшн суулгаад хяналт тавих боломжтой, одоогоор цагдаагийн байгууллагын 350 алба хаагчдад хандах эрх нээсэн.

Энэхүү системийг хийсэн Дижитал медик ХХК-ны инженерүүдтэй уулзаж ярилцахад: - цагдаагийн эрх олгодсон алба хаагч өөрийн харьяалах нутаг дэвсгэрт хяналт тогтоох, малчны хотноос гарч, орж байгаа малыг хянах бөгөөд системийг ашиглан мал хулгайлах гэмт хэрэг гарсан газрын зураглалыг гаргаж, алдагдсан малыг ойр байгаа аймаг, сумын малын эмч нарт сүлжээгээр дамжуулж мэдээлэх, санал солилцох, сэрэмжлүүлэг өгөх, гарсан хэргийг шуурхай илрүүлэх чиглэлээр ашиглах боломжтой бөгөөд цагдаагийн байгууллагаас хүсэлтээ ХХААХҮЯ-нд гаргавал төлбөргүйгээр шийдвэрлэх боломжтой, системийг бүрэн ашигласнаар мал хулгайлах гэмт хэрэг 50-80 хувь буурах магадлалтай талаар тайлбарлаж байлаа.

<sup>17</sup> Мал эмнэлгийн ерөнхий газрын Танилцуулга 2019 он

<sup>18</sup> Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн инженер цагдаагийн ахмад Л.Ганзоригийн ажлын мэдээнээс

Зураг – 33. Мал эмнэлгийн гэрчилгээ

МАЛ ЭМНЭЛГИЙН ГЭРЧИЛГЭЭ

- МЭГ-гийн МАЛЫН ЭМЧИЙН НЭР
- МЭГ-ас ОЛГОСОН ДУГААР
- АМЬД МАЛЫН МЭДЭЭЛЭЛ
- МАЛЫН ГАРЛАЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ МЭДЭЭЛЭЛ
- Хүчинтэй хугацаа: 2018.08.08 - 2018.08.11
- МАРШРУТЫН МЭДЭЭЛЭЛ
- БЭЛЧЭЭРИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН МЭДЭЭЛЭЛ
- ГАРАЛ ҮҮСЛИЙН МЭДЭЭЛЭЛ
- ТЭЭВЭРЭЛТИЙН ЯВЦАЛ ХАРИУЦАХ ХҮНИЙ МЭДЭЭЛЭЛ
- ХҮРЭХ ГАЗРЫН МЭДЭЭЛЭЛ
- ТУСТАЙ БАР КОД, САНАМЕЖИЙН ХЭСЭГ

Зураг – 34. Мал тоологч төхөөрөмж



Мал эмнэлгийн гэрчилгээ нь зөвшөөрөл олгосон малын эмчийн нэр, малчны хаяг, малын нас, зүс, хүйс, хүрэх газрын мэдээлэл зэргийг харах боломжтой тул хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдал болон хулгайгаас урьдчилан сэргийлэх хяналт тавихад тохиромжтой ажээ. Хяналтын төхөөрөмж нь авто замын постуудад ажиллаж байгаа алба хаагч авто машинд ачигдсан болон тууварлагдан ирж байгаа малыг тоолох бөгөөд гэрчилгээгүй малыг хянах боломжтой төхөөрөмж байна.

Зураг – 35. Бар кодоор гарал үүслийг гаргаж, хүнсний аюулгүй байдлыг хянах

Гарал үүсэл

Аймаг, хот: Архангай  
Сум, дүүрэг: Өндөр-Улаан  
Баг, хороо: Донгой  
Үйлдвэр: Мах маркет ХХК

Код оруулах

Шалгах

ХХААХҮЯ-аас олгодог малын “бар” код худалдаалагдаж байгаа махан дээр малын гарал үүслийн мэдээллийг тавигдах бөгөөд хүнсний аюулгүй байдалд ач холбогдолтой.

**8.2. Малчин лавлах - 109** ХХААХҮЯ-ны харьяа Малчин лавлах - 109 мэдээллийн төвийг 2019 оны 01 сараас эхлэн ажлуулж, 6000 гаруй дуудлага ирсэнээс алдсан, олдсон малын зар 215, алдсан малаа бүртгүүлж зарлуулсны үр дүнд 8 малчин 15 бод малаа олжээ. Малчин лавлах-109 утасны операторууд алдсан, олсон малын зарыг тэмдэглэн авч ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн албаны Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэст мэдэгдэхээс гадна өндөр хандалттай алдсан малын чиглэлийн фейсбүүк группүүд болон Эх орон телевизээр 7 хоногийн 5 өдөр 16 цаг 50 минутад нэвтрүүлж байна. Долоо хоног бүр 21 аймгаас 330 сумын цаг үеийн байдлын судалгаа мэдээллийг авдаг байна.



Эрүүгийн цагдаагийн албаны Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэстэй хамтарч ажилласны үр дүнд мал хулгайлсан хоёр бүлэг этгээдүүдийг илрүүлсэн бөгөөд тэмдэглэгдсэн бүх зарыг орон нутгийн цагдаагийн байгууллагад нь мэдэгддэг байна.

Малчин лавлах -109 дугаар руу үүрэн телефоны дугаараас залгахад үнэ төлбөргүй бөгөөд өглөө 08 цаг 30 минутаас үдшийн 20 цаг 00 хүртэл ажиллаж, ХХААХҮЯ-наас хэрэгжүүлж буй бодлого, шийдвэрүүд, малын түүхий эд, мал, махны үнэ ханш, цаг агаарын мэдээ, арьс, шир ноосны урамшуулал, малчны тэтгэвэр тэтгэмж, нийгмийн даатгалын талаар бодит мэдээллийг түргэн, шуурхай малчдад хүргэдэг байна.

**8.3.** Малын ээмэг нь малын тоо толгойд хяналт тавьж, тоон болон статистик мэдээллийг үнэн бодитой гаргах, мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хяналт тавих малын ээмэг олон улсын стандарт шаардлагад нийцсэн олон төрлөөр үйлдвэрлэгдсэн бөгөөд бүх орон нутагт жигд хэрэгжүүлэх шаардлагатай байна.

**Зураг – 37. Малын таних тэмдэг**



нөлөөнд өртөхөөргүйгээр хийгддэг<sup>19</sup>.

Малыг найдвартай, төвөггүй ялган тэмдэглэх, хаана ч байсан ямар арга хэмжээнд хамрагдсан зэргийг тодорхой харуулсан бүртгэлтэй байх хэрэгтэй байна. Ээмэг нь -50 градуст хөлдөж хугарахгүй, унахгүй, түгжээ сайтай, харшлах зүйлгүй, ээмгэн дээр мал тус бүрт дахин давтагдахгүй кодоор дугаарлан, стандартын дагуу лазерын машинаар бичдэг бөгөөд цаг агаараас шалтгаалах гадны хүчин зүйлийн

## ДҮГНЭЛТ

Мал сүрэг нь Монгол Улсын үндэсний өвөрмөц, нөхөн сэргээгдэх баялаг, соёл, уламжлалыг хадгалан авч яваа дэлхийн үнэт өв бөгөөд тогтвортой хөгжлийн үндэс, эдийн засгийн тулгуур, хүн амын амьжиргааны эх үүсвэр, хүнсний аюулгүй байдлын баталгаа, малчин өрхийн эдийн засгийн үндэс юм. Ийм учраас Монгол Улсын Үндсэн хуулинд “Мал сүрээ бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтанд байна” гэж заасан боловч төрийн хамгаалалтанд бүрэн орж чадахгүй зах зээлийн эрэлт хэрэгцээ болж гэмт халдлагад өртсөөр байна.

1. Мал хулгайлах гэмт хэргийн ихэнхийг урьдчилан бэлдсэн багаж хэрэгсэл, агуулах сав, автомашин ашиглан үгсэн тохиролцсон бүлэг гэмт этгээдүүд зохион байгуулалттайгаар богино хугацаанд, нотлох баримт, ул мөр үлдээхгүйгээр үйлдэж, ихээхэн хэмжээний ашиг олж, хүрээгээ тэлсээр байна.

2. Монгол улсаас гадаадад экспортлох махны эрэлт нэмэгдэж, үйлдвэрүүдийн махны нийлүүлэлт ихэссэнтэй холбогдуулан БНХАУ-ын иргэд махыг их хэмжээгээр худалдан авч, нөөцлөх байдлаар үнийн хөөрөгдөлтийг тодорхой цаг хугацаанд бий болгосон, хотжилтын үйл явцтай холбоотойгоор мах, махан бүтээгдэхүүний хэрэгцээ тогтмол өсөж байгаа энэ үед улсын нөөцийн махны хэмжээ бага нийлүүлэгдсэн нь махны зах зээлийн үнэ нэмэгдэж, улмаар мал хулгайлах гэмт хэрэг өсөх үндсэн шалтгаан болсон байна.

3. Монгол Улсын Засгийн газраас махны экспортод улирлын чанартай квот тогтоон, махны үнийг тогтвортой барих бодлого боловсруулан, үнийн хөөрөгдөлтийг зогсоохын зэрэгцээ мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр аймаг, орон нутгийн засаг захиргааны нэгжид үр дүнтэй ажил зохион байгуулах үүрэг чиглэлийг өгөх шаардлагатай байна.

4. Улсын хэмжээнд 2018 онд өмчийн, халаасны, авто машины хулгай өмнөх онтой харьцуулахад 30.5 - 66.3 хувиар тус тус буурсан бол мал хулгайлах гэмт хэрэг 2017 онд 11.9, 2018 онд 21.6 хувиар тус бүр өссөн, хэргийн илрүүлэлт 5.2-1.2 хувиар буурсан нь энэ чиглэлээр ажиллаж байгаа нэгжийн үйл ажиллагааг идэвхжүүлж, бэхжүүлэх, техник хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулах зайлшгүй шаардлагатай байна.

5. Орон нутгийн засаг захиргаанаас мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр Малын эрүүл мэндийн хяналтын системийг бүх аймаг, сумдад шуурхай нэвтрүүлэх, цахим сүлжээг ашиглан харилцан мэдээлэл, туршлага солилцох ажлыг идэвхжүүлж, ихээр алдагдаж байгаа бод малд чип суулгах, малчдын малын хариулга маллагааг сайжруулах, бүл, чадал

<sup>19</sup> Тэргүүн сүрэг ХХК танилцуулга

муутай өрх айлуудыг хот айлын зохион байгуулалтанд оруулж, хөдөлмөрөөрөө хорших зэрэг уламжлалт ажлыг сэргээн, энэ гэмт хэргийн эсрэг малчид идэвхитэй хамтарснаар амар хялбар байдлаар орлого олох хүсэлтэй малын хулгайч нарыг зогсоох боломж бий болно.

6. Мал хулгайлах гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах хуулийн хариуцлага, ялын хэмжээ хөнгөн байгаа нь малын хулгайч нарт нөлөөлөхгүй байгаагаас хулгай хийж байгаа хүний тоо нэмэгдэх, дахин давтан гэмт хэрэг үйлдэх үндсэн шалтгаан болж байгаа тул холбогдох хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

7. Цагдаагийн байгууллагын нэр хүндийг хөдөө, орон нутагт мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажил илэрхийлж байдаг тул энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр шинэ арга барил, шуурхай авто машин, техник хэрэгсэл, технологийн дэвшлийг ашиглах шаардлагатай байна. Мөн малчдын сайн дурын бүлэг, нөхөрлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэн, тэднийг урамшуулах, үйл ажиллагааг нь сурталчлах, гэмт хэргийн талаарх бодит мэдээллийг үнэ төлбөртэй авах, малчдын мэдээллийн сүлжээг үүсгэж, харилцан мэдээлэл солилцох зэрэг ажлыг сайжруулах нь хэргийн илрүүлэлтэд үр дүн үзүүлнэ гэж үзэж байна.

8. Дотоодын махны үйлдвэрүүдэд боловсруулсан мах 2018 онд экспортолсон махнаас 5000 тн орчмоор зөрж байгаа бөгөөд экспортод гарсан мах дулааны аргаар боловсруулсан гэж тооцоход нядалсан болон боловсруулалтаас хөнгөрсөн махны хэмжээ 45-50 орчим хувь гэж үзвэл нийт 7-8 орчим тн мах ямар байдлаар экспортод гарсан нь тодорхойгүй харагдаж байх тул мах экспортод гаргах үйл ажиллагаа далд нууц байдлаар явагдаж байгаа эсэхэд хяналт тавих шаардлагатай байна.

9. Сүүлийн жилүүдэд олон аж ахуйн нэгж мах бэлтгэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж, махыг дулааны аргаар хагас боловсруулан хадгалж, багагүй ашиг орлого олсон тул цаашид хэрэгцээг нэмэгдүүлж, мал хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдал хүндрэх, энэ төрлийн гэмт хэрэг үйлддэг этгээдүүдийн үйл ажиллагаа идэвхжих шалтгаан болж байна.

## **САНАЛ, ЗӨВЛӨМЖ**

### **1. Хууль зүй, Дотоод хэргийн яам:**

***1.1. Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дараах заалтуудад өөрчлөлт оруулах санал:***

#### ***Эрүүгийн хуулинд:***

- Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйлийн 12 дахь заалтад “олон тооны мал” гэдэгт 24 бог, 8 бодоос дээш малыг тооцохоор хуульчилсан нь нэг үйлдлээр 23 бог, 7 бод мал хулгайлбал хүндрүүлэх нөхцөл бололгүй, хөнгөн хэргийн ялыг оногдуулж байгаа нь малчид, иргэдээс байнгын шүүмжлэл дагуулж, хулгайч нарт ял завших боломжийг олгож байна. /Зах зээл дээр 2019 оны 05 дугаар сарын байдлаар нэг эр хонь 150.000-280.000 төгрөг, нэг эр үхэр 1.200.000-1.700.00 төгрөг гэж үзвэл мал хулгайлсан этгээдийн нэг удаагийн үйлдлээр 23 хонь буюу 3.450.000 төгрөг, 7 үхэр буюу 8.400.000 төгрөгийн хохирол учруулсан байхад хүнд гэмт хэрэг гэж үзэхгүй, хөнгөн хэргийн ангилалд хамааруулж ял оноохоор байна/
- Сүүлийн үед үйлдэгдсэн мал хулгайлах гэмт хэрэг ихэвчлэн суудлын авто машин ашиглах нь ихсэж байгаа тул хуулинд хохирлыг 4 бог, 2 бод малаас дээш байхаар хуульчлах. /жижиг тээврийн хэрэгсэлд 3-4 бод, 5-6 бог мал тээвэрлэгддэг байна/
- Мал хулгайлах гэмт хэргийг ихэвчлэн урьдчилан үгсэн тохирч тусгайлан бэлдсэн зэвсэг, хэрэгсэл, үүрэн холбоо, авто машин ашиглан үйлддэг, гэтэл оногдуулах хуулийн хариуцлага харьцангуй сул байгааг харгалзан, Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйлийн 12 дахь заалтад “учрах саадыг арилгах зорилгоор зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж, машин механизм ашиглаж үйлдсэн” гэсэн хүндрүүлэх нөхцлийг нэмж оруулах.



- Зөрчлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 5 дахь заалтад “худалдан авсан, борлуулсан” үйлдлийг нэмэх. /Энэ нь гэмт хэргийн замаар мал, мах, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг зах зээлд борлогдохоос урьдчилан сэргийлэх боломжтой/
- Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйл 17.1.2.4 заасан хүндрүүлж үзэх нөхцөл байдлыг мөн хуулийн 17.12-т хүндрүүлэх нөхцөл байдалд хамааруулах, хуулийн 17.12.1-т заасан нийтэд тустай ажил хийлгэх ялыг хүчингүй болгох;

**Зөрчлийн тухай хуульд:** 13.5 дугаар зүйлд 1.1.мал, мах бэлтгэлийн зориулалтаар гарал үүслийн гэрчилгээгүй мал тууварласан, эсхүл мал, мах тээвэрлэсэн гэсэн заалтад “худалдаалсан” гэх үгийг нэмэх этгээдэд хариуцлага хүлээлгэх заалтыг нэмж тусгаснаар гэмт хэргийн замаар алдагдсан мал, мах, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг зах зээлд зарж борлогдохоос урьдчилан сэргийлэх ач холбогдолтой байна.

**1.2. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:**

- ХХААХҮЯамтай хамтран мах нөөцөлж байгаагаас үүдэлтэй үнийн хөөрөгдөлтийг зогсоох, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр орон нутгийн засаг захиргаанаас үр дүнтэй ажил зохион байгуулах үүрэг чиглэлийг өгөх;
- Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр орон нутгийн хууль хяналтын байгууллагын хамтын ажиллагааг сайжруулж, мал хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдэд оногдуулах ялын бодлогыг чангатгах талаар анхаарах;
- ХХААХҮЯ-наас хэрэгжүүлж буй малын цахим бүртгэлийн сан, мал эмнэлгийн гэрчилгээг орон нутагт яаралтай, жигд хэрэгжүүлэх ажлыг идэвхижүүлэн дэмжих;
- Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр зохион байгуулах ажлын зардлыг тусгайлан төсөвлөж, “Малын хулгайгүй баг, сум”-ыг шалгаруулан, малчдын сайн дурын бүлэг, нөхөрлөлийн үйл ажиллагааг идэвхижүүлж, урамшуулан, сайн үйл ажиллагаатай бүлэг, нөхөрлөлийг сурталчлах, нийтийн хүртээл болгох;

**2. Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яам:**

- Мал, мах бэлтгэх, худалдан борлуулах, боловсруулах, экспортод гаргах махны квотыг тогтоож, мах бэлтгэх үйлдвэрүүдэд тавих хяналтыг сайжруулан, малчны гараас шууд үйлдвэрт очих, үйлдвэрээс хэрэглэгчид очих тогтолцоог бий болгох, махны үнийг тогтворжуулах чиглэлээр холбогдох яам, агентлаг, салбар нэгжүүдтэй хамтран ажиллах;
- “Монгол мал - 2” хөтөлбөрийн хүрээнд малын цахим бүртгэлийн сан, мал эмнэлгийн гэрчилгээг улс даяар яаралтай хэрэгжүүлж, малыг бүртгэлжүүлэх, ээмэгжүүлэх, хулгайд ихээр өртөж байгаа бод малыг чипжүүлэх зэрэг ажлыг орон нутгийн удирдлага, цагдаагийн байгууллагатай хамтран зохион байгуулах;
- Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2018 оны Мал эмнэлгийн гэрчилгээний загвар, хэрэглэх зааварт өөрчлөлт оруулж, ...“Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг сум, дүүргийн нутаг дэвсгэрээс гадагш чиглэсэн тохиолдлууд буюу худалдаалах, төхөөрөх, олон нийтийг хамарсан арга хэмжээнд оролцуулах, мал, амьтан шилжүүлэн авах, отор нүүдэл хийх, хээлтүүлэгт ашиглах болон бусад зорилгоор шилжилт хөдөлгөөн хийх үед мал эмнэлгийн гэрчилгээ заавал авна. **Худалдаалах зорилгоор бус, хувийн хэрэгцээндээ тээвэрлэж яваа бага хэмжээний мах, махан бүтээгдэхүүнд мал эмнэлгийн гэрчилгээ авахгүй байж болно**” гэж заасан хэсгийг хасах;

**3. ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх хэлтэс, ЭЦГ-ын Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэст:**

- Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрүүдэд хууль, хяналт, татварын байгууллагуудын нэгдсэн шалгалтыг хийж, байгаль орчинд хохирол учруулахгүй, стандарт шаардлагад нийцсэн, татвар төлөлтийн байдал зэрэг хуулийн хэрэгжилтийг шалгахын зэрэгцээ мах экспортлох квотын эрхээ дамлах, зориулалтын бус газар мах боловсруулж байгаа байдалд хяналт шалгалт явуулах.
- Мал эмнэлгийн гэрчилгээний нэгдсэн системийн сүлжээгээр дамжуулан иновацийг нэвтрүүлж, алдагдсан малын цахим зураглалыг гарган, ойр аймаг, сум, багийн малын эмч

нартай харилцан мэдээлэл солилцож, сэжигтэй малын мэдээллийг авч илрүүлэх талаар Мал эмнэлгийн ерөнхий газар, төслийн багтай зөвшилцөж, үйл ажиллагаандаа ашиглах.

- Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, хулгайгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газруудаас хийсэн шинэлэг шторк, санамж, сэрэмжлүүлгийг нэгтгэн улс даяар цацагддаг телевиз, радио, “Малчин” болон орон нутгийн телевиз, сайтууд, иргэд, малчдын уулзалт, хурал зөвлөгөөн, худалдаа үйлчилгээ явуулдаг газруудад байршуулж, сурталчлан хүргэх ажлыг зохион байгуулах.
- Мал эмнэлгийн гэрчилгээг улс даяар хэрэгжүүлснээр мал хулгайлах гэмт хэрэг буурахад нөлөөлөх тул холбогдох газартай хамтран сурталчлах ажлыг зохион байгуулах.

#### **4. Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага:**

- Мал хулгайлах гэмт хэрэг үйлдэж шүүхээр шийтгэгдсэн 1475 ялтан 2015 оны Өршөөл үзүүлэх тухай хууль, 2017 оны Эрүүгийн хуулийн тэгшитгэлд хамрагдаж суллагджээ. Сүүлийн жилүүдэд энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгчдийн тоо нэмэгдэж, 2-3 удаа ял шийтгэгдсэн, мөрдөн шалгах ажиллагааны арга тактикийг сайтар судалсан, байцаалт мэдүүлэг өгөх, гэмт хэргийн ул мөрийг далдлах, баллах, цагдаагийн ажилтанд эргэлзээ төрүүлэх, төөрөлдүүлэх, арга барилд гаршсан этгээдүүд уг гэмт хэргийг үйлдэж байх тул энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр орон нутгийн төр, захиргаа, хуулийн байгууллагуудтай хамтран ажиллах ажлыг эрчимжүүлэх.
- Хэсгийн төлөөлөгч, мөрдөгчөөр томилогдон ажиллаж байгаа алба хаагчдад зааварчлага тогтмол өгч, зэвсэг хэрэгсэл, машин техник ашиглан үйлдэгдсэн хэргийг хэрхэн илрүүлэх, ул мөрийн тогтоох, бэхжүүлэх, малын зүс, хүйс, нас, эм тамга зэргийн талаар мэдлэгийг сайжруулах, хэргийг илрүүлэх арга ажиллагааны талаар зааж сургах ажлыг зохион байгуулах.
- Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг дан ганц цагдаагийн байгууллага хийхэд хүн хүч, зардлын хувьд хүндрэлтэй тул малчдын бүлэг, нөхөрлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, тэднийг урамшуулах, бүл чадал муутай айлуудыг хот айлын зохион байгуулалтанд оруулж, хөдөлмөрөөрөө хорших уламжлалт ажлыг сэргээх чиглэлээр орон нутгийн засаг захиргаатай хамтран хэрэгжүүлэх.
- Мал эмнэлгийн гэрчилгээний нэгдсэн систем хэрэгжиж байгаатай холбогдуулан сумын хэсгийн төлөөлөгч, цагдаа нарыг сүлжээнд холбон, малын эмч нар мал эмнэлгийн гэрчилгээг хуулийн дагуу олгож байгаа эсэхэд хяналт тавьж, алдагдсан малын цахим зураглалыг гарган, аймаг, сум, багийн малын эмч нарт сэрэмжлүүлэх, мэдээлэл солилцож, хэрэг илрүүлэх ажиллагаанд ашиглах.
- Мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрүүд дээр тавих хяналтыг тогтмолжуулж, байнгын болон улирлын чанартай ажилладаг махны ченж нарыг бүртгэлжүүлж хянахын зэрэгцээ хулгайн мал, мах борлуулдаг сүлжээг илрүүлэх ажлыг эрчимжүүлэх.
- Мал хулгайлах гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн 49.3 хувь нь малчид байх тул тэдэнд чиглэсэн хууль эрх зүйн болон бусад сургалтыг зохион байгуулж, нэг бүрчилсэн урьдчилан сэргийлэх ажлыг тогтмолжуулах.
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай хамтран мах төхөөрөх, боловсруулах үйлдвэр, зах худалдааны төв, авто замын пост зэрэг хяналт тавих шаардлагатай газруудад мал эмнэлгийн гэрчилгээтэй мах ирж байгаа эсэхийг хянах, илэрсэн зөрчлийг арилгуулах, хариуцлага тооцох, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэх ажлыг зохион байгуулах.
- Орон нутгийн удирдлагатай хамтран малын биед чип суулгах, мөшгөлтийн шинэ аргыг хэрэглэн гар утсаараа малаа хянах төхөөрөмжийн талаар судалж, мэдээллийг малчдад түгээх, алдуул малыг зарлуулах, санамж сэрэмжлүүлгийг тогтмол өгч, харилцан мэдээлэл солилцох сүлжээг идэвхижүүлэх зэрэг ажлыг зохион байгуулах зэрэг саналтай байгааг танилцуулж байна.

МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ, ШУУРХАЙ АЛБАНЫ  
ДҮН ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

